



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: ДГА-2026/72/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Сайншанд сум
2026 он

Дарга, тэргүүлэх аудитор:
Цахим хаяг:
Аудитын менежер:
Цахим хаяг:
Ахлах аудитор:
Цахим хаяг:
Аудитор:
Цахим хаяг:

Т.Ган-Өлзий
gan-ulziit@audit.gov.mn
У.Оюунтүлхүүр
oyuntulkhuur.u@audit.gov.mn
О.Нарангарав
narangarav.o@audit.gov.mn
Н.Түвшинбаатар
tuvshinbaatar.n@audit.gov.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд судамж,
3 дугаар баг, Сайншинд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (976) 7052 2734

Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn
2026.02.25 № 1-6/101

тантай _____-ны № _____-т

ДАЛАНЖАРГАЛАН СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН
ГАЗРЫН ДАРГА Б.ОЮУНБЯМБА
ТАНАА

Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Даланжаргалан сумын Засаг даргын Тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дүгнэлтийн үндэслэл хэсэгт дурдсан буруу илэрхийлэл нь материаллаг боловч өргөн тархаагүй гэж үзсэн бөгөөд санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг эс тооцвол Дорноговь аймгийн Даланжаргалан сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Батлагдсан төсвийн нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас бичиг хэргийн материал 0.04 сая төгрөгөөр, урсгал засварын зардлаас 0.3 сая төгрөгөөр жааз худалдан авч зориулалт бусаар зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэж заасантай нийцэхгүй байна.

Урсгал засварын 10.6 сая төгрөгийн өглөгийг Осо констракшин ХХК-тай, бичиг хэргийн материалын үнэ 0.4 сая төгрөгийн өглөгийг Нийтлэг үйлчилгээний газартай, бараа материалын 0.2 сая төгрөгийн өглөгийг иргэнтэй нийт 11.2 сая төгрөгийн өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20.2.6 "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах" гэж заасантай нийцэхгүй байна.

Иргэдийн дунд "Гар бөмбөгийн тэмцээн, уралдаан" зохион байгуулж 0.6 сая төгрөгийг зарцуулсан нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15.1.8."байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

442505063

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>257,491,336.85</u>	<u>269,288,476.15</u>
33	АВЛАГА	60,759,249.70	57,991,050.70
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	671,053.00	223,244.00
335	Бусад авлага	60,088,196.70	57,767,806.70
3351	Байгууллагаас авах авлага	58,792,832.70	57,767,806.70
3352	Хувь хүмүүсээс авах авлага	1,295,364.00	-
35	БАРАА МАТЕРИАЛ	196,732,087.15	211,297,425.45
351	Түүхий эд материал	3,487,500.00	15,308,750.00
35110	Тусгай зориулалттай материал	3,487,500.00	15,308,750.00
354	Хангамжийн материал	193,244,587.15	195,988,675.45
35410	Бичиг хэргийн материал	3,590,600.00	4,042,180.00
35420	Аж ахуйн материал	169,086,675.45	189,986,495.45
35430	Сэлбэг хэрэгсэл	19,894,311.70	1,960,000.00
35440	Түлш, шатах тослох материал	673,000.00	-
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>4,016,050,294.44</u>	<u>3,806,748,587.37</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	4,016,050,294.44	3,806,748,587.37
392	Биет хөрөнгө	3,883,185,394.60	3,673,883,687.53
39201	Барилга, байгууламж, орон сууц	2,814,075,900.57	2,814,075,900.57
39202	Хуримтлагдсан элэгдэл	-	- 592,477,451.55
39203	Авто-тээврийн хэрэгсэл	490,367,725.00	486,042,925.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-	- 355,229,359.42
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	352,902,283.00	391,254,677.93
39206	Хуримтлагдсан элэгдэл	-	- 211,144,776.45
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	508,878,420.30	517,757,113.50
39208	Хуримтлагдсан элэгдэл	-	- 240,682,809.04
39209	Зам, гүүрийн байгууламж	633,521,490.00	731,887,431.00
39210	Хуримтлагдсан элэгдэл	-	- 449,976,665.10
39214	Бусад үндсэн хөрөнгө	770,169,703.30	770,169,703.30
39215	Хуримтлагдсан элэгдэл	-	- 187,793,002.21
393	Биет бус хөрөнгө	132,864,899.84	132,864,899.84
39301	Програм хангамж	3,686,000.00	3,686,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-	- 3,633,000.16
39303	Бусад биет бус хөрөнгө	132,811,900.00	132,811,900.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>4,273,541,631.29</u>	<u>4,076,037,063.52</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>10,587,182.00</u>	<u>58,299,901.00</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	10,587,182.00	58,299,901.00
413	Өглөг	10,587,182.00	58,299,901.00
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	9,664.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	10,577,518.00	12,995,401.00
4136	Бусад өглөг	-	45,304,500.00
41361	Байгууллагад төлөх өглөг	-	44,914,500.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	-	390,000.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>4,262,964,113.29</u>	<u>4,017,737,159.52</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	4,262,964,113.29	4,017,737,159.52
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	1,170,529,816.54	1,170,529,816.54
51101	Өмч: - төрийн	1,170,529,816.54	1,170,529,816.54
512	Хуримтлагдсан үр дүн	2,964,300,822.54	2,719,073,868.77
51210	Өмнөх үеийн үр дүн	2,964,300,822.54	2,964,300,822.54
51220	Тайлант үеийн үр дүн	-	- 245,226,953.77
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	128,133,474.21	128,133,474.21
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>4,273,541,631.29</u>	<u>4,076,037,060.52</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,784,164,658.13	1,510,896,363.93
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	392,477,400.00	238,098,733.93
120	Нийтлэг татварын бус орлого	392,477,400.00	238,098,733.93
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	392,477,400.00	238,098,733.93
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,762,600.00	5,345,905.00
1200043	Үнэ төлбөргүй үлээн авсан -Үндсэн хөрөнгө	329,357,400.00	173,762,828.93
1200044	Үнэ төлбөргүй үлээн авсан -Бараа материал	59,357,400.00	58,990,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,391,687,258.13	1,272,797,630.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	353,084,017.00	60,077,430.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	300,909,037.00	24,310,430.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	46,674,980.00	35,767,000.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,038,603,241.13	1,212,720,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,038,603,241.13	1,212,720,200.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,570,655,201.42	1,754,613,465.74
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,570,655,201.42	1,754,613,465.74
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,570,655,201.42	1,623,303,217.31
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	734,394,313.05	796,461,616.00
210101	Үндсэн цалин	343,997,248.00	409,446,367.00
210102	Нэмэгдэл	309,469,807.05	273,884,041.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,194,052.00	56,360,179.00
210104	Урамшуулал	30,209,159.00	37,144,710.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,524,047.00	19,626,319.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,262,214.45	101,045,324.03
210201	Тэтгэврийн даатгал	62,142,290.51	68,090,538.50
210202	Тэтгэмжийн даатгал	7,510,858.70	8,161,508.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,729,080.95	4,237,884.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,647,487.64	4,005,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,232,496.65	16,550,193.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,707,639.63	72,097,085.39
210301	Гэрэл, цахилгаан	22,689,120.85	25,961,536.39
210302	Түлш, халаалт	39,734,451.78	42,376,145.00
210303	Цэвэр, бохир ус	8,284,067.00	3,759,404.00
2104	Хангамж, бараа материалын зардал	32,940,059.00	81,204,015.85
210401	Бичиг хэрэг	3,650,000.00	3,631,920.00
210402	Тээвэр, шатахуун	21,204,160.00	24,605,858.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,075,899.00	4,387,496.15
210404	Ном, хэвлэл	-	163,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	187,700.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,822,300.00	23,874,750.00
210408	Бараа материал акталсны зардал	-	24,420,491.70
2105	Нормативт зардал	508,500.00	502,560.00
210502	Хоол, хүнс	508,500.00	502,560.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,223,600.00	1,260,000.00
210604	Урсгал засвар	4,223,600.00	1,260,000.00
2107	Томилолт, зочны зардал	9,122,600.00	11,560,000.00
210702	Дотоод албан томилолт	9,122,600.00	11,560,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	265,703,582.00	125,167,932.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	263,052,024.00	122,405,250.00
210803	Даатгалын үйлчилгээ	643,275.00	843,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	328,667.00	53,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	200,000.00
210807	Газрын төлбөр	1,525,616.00	1,666,472.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	361,792,693.29	434,004,684.04
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	16,950,050.00	51,145,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	875,000.00	-

210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	343,967,643.29	382,859,684.04
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	-	131,310,248.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	131,310,248.43
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	213,509,456.71	-
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	3,290,000.00	1,509,851.96
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	-	1,509,851.96
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	3,290,000.00	
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(3,290,000.00)	(1,509,851.96)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	210,219,456.71	(245,226,953.77)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,412,554,599.83	1,337,768,231.70
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,134,600.00	5,345,905.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,134,600.00	5,345,905.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,134,600.00	5,345,905.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,134,600.00	5,345,905.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,408,419,999.83	1,332,422,326.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	369,816,758.70	119,702,126.70
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	5,500,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	300,909,037.00	24,310,430.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	63,407,721.70	95,391,696.70
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	1,038,603,241.13	1,212,720,200.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	1,038,603,241.13	1,212,720,200.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,283,936,099.83	1,336,463,231.70
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,283,936,099.83	1,336,463,231.70
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,225,606,767.13	1,147,517,176.57
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	735,055,702.05	796,023,471.00
210101	Үндсэн цалин	344,210,828.00	409,008,222.00
210102	Нэмэгдэл	309,917,616.05	273,884,041.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	49,194,052.00	56,360,179.00
210104	Урамшуулал	30,209,159.00	37,144,710.00
210105	Гэрээт ажлын хөлс	1,524,047.00	19,626,319.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	91,262,214.45	101,045,324.03
210201	Тэтгэврийн даатгал	62,142,290.51	68,090,538.50
210202	Тэтгэмжийн даатгал	7,510,858.70	8,161,508.05
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,729,080.95	4,237,884.16
210204	Ажилгүйдлийн даатгал	1,647,487.64	4,005,200.00
210205	Эрүүл мэндийн даатгал	15,232,496.65	16,550,193.32
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	70,751,639.63	72,097,085.39
210301	Гэрэл, цахилгаан	22,689,120.85	25,462,836.39
210302	Түлш, халаалт	45,436,686.78	42,874,845.00
210303	Цэвэр, бохир ус	2,625,832.00	3,759,404.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,067,749.00	64,103,704.15
210401	Бичиг хэрэг	4,184,300.00	3,405,500.00
210402	Тээвэр, шатахуун	11,917,550.00	14,792,658.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,075,899.00	4,387,496.15
210404	Ном, хэвлэл	303,000.00	53,500.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	120,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	4,467,000.00	41,344,550.00
2105	Нормативт зардал	469,000.00	544,560.00
210502	Хоол, хүнс	-	502,560.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	469,000.00	42,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	8,258,900.00	5,097,700.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,300,000.00	-
210602	Тавилга	-	580,000.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	316,500.00	-
210604	Урсгал засвар	6,642,400.00	4,517,700.00

2107	Томилолт, зочны зардал	9,122,600.00	11,560,000.00
210702	Дотоод албан томилолт	9,122,600.00	11,560,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	284,511,962.00	92,045,332.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	281,837,404.00	89,282,650.00
210803	Даатгалын үйлчилгээ	643,275.00	843,210.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	328,667.00	53,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	177,000.00	200,000.00
210807	Газрын төлбөр	1,525,616.00	1,666,472.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1,107,000.00	5,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	232,000.00	5,000,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	875,000.00	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	58,329,332.70	188,946,055.13
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	131,310,248.43
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	131,310,248.43
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	58,329,332.70	57,635,806.70
213405	нэмэлт санхүүжилт	58,329,332.70	57,635,806.70
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	128,618,500.00	1,305,000.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	128,283,700.00	1,305,000.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	128,283,700.00	1,305,000.00
2200	Дотоод эх үүсвэрээр	128,283,700.00	1,305,000.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	128,283,700.00	1,305,000.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	(128,283,700.00)	(1,305,000.00)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	334,800.00	
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	төгрөгөөр
					Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,170,529,816.54	128,133,474.21	2,754,415,815.83	4,053,079,106.58
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,170,529,816.54	128,133,474.21	2,754,415,815.83	4,053,079,106.58
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	210,219,456.71	210,219,456.71
C08	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,170,529,816.54	128,133,474.21	2,964,300,822.54	4,262,964,113.29
D01	2025 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	1,170,529,816.54	128,133,474.21	2,964,300,822.54	4,262,964,113.29
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,170,529,816.54	128,133,474.21	2,964,300,822.54	4,262,964,113.29
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	-	-	-
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(245,226,953.77)	(245,226,953.77)
D09	2025 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,170,529,816.54	128,133,474.21	2,719,073,868.77	4,017,737,159.52

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны			
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,235,307,400.0	1,086,755,856.5	148,551,543.4	88.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,235,307,400.0	1,086,755,856.5	148,551,543.4	88.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,234,907,400.0	1,086,755,856.5	148,151,543.4	88.0
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	829,538,700.0	796,023,471.0	33,515,229.0	96.0
210101	Үндсэн цалин	406,170,800.0	409,008,222.0	(2,837,422.0)	100.7
210102	Нэмэгдэл	276,365,800.0	273,884,041.0	2,481,759.0	99.1
210103	Унаа хоолны хөнгөлөлт	66,990,000.0	56,360,179.0	10,629,821.0	84.1
210104	Урамшуулал	51,500,100.0	37,144,710.0	14,355,390.0	72.1
210105	Гэрээт ажлын хөлс	28,512,000.0	19,626,319.0	8,885,681.0	68.8
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	103,692,400.0	101,045,324.0	2,647,075.9	97.4
210201	Тэтгэврийн даатгал	70,048,100.0	68,090,538.5	1,957,561.5	97.2
210202	Тэтгэмжийн даатгал	8,411,000.0	8,161,508.0	249,491.9	97.0
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,205,900.0	4,237,884.1	(31,984.1)	100.8
210204	Ажилгүйдлийн даатгал	4,205,900.0	4,005,200.0	200,700.0	95.2
210205	Эрүүл мэндийн даатгал	16,821,500.0	16,550,193.3	271,306.6	98.4
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	93,323,900.0	72,097,085.3	21,226,814.6	77.3
210301	Гэрэл, цахилгаан	35,250,000.0	25,462,836.3	9,787,163.6	72.2
210302	Түлш, халаалт	52,887,900.0	42,874,845.0	10,013,055.0	81.1
210303	Цэвэр, бохир ус	5,186,000.0	3,759,404.0	1,426,596.0	72.5
2104	Хангамж, бараа материалын зардал	22,360,100.0	19,733,944.1	2,626,155.8	88.3
210401	Бичиг хэрэг	3,400,000.0	3,405,500.0	(5,500.0)	100.2
210402	Тээвэр, шатахуун	12,223,600.0	11,046,688.0	1,176,912.0	90.4
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,256,500.0	3,658,756.1	597,743.8	86.0
210404	Ном, хэвлэл	400,000.0	-	400,000.0	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	280,000.0	120,000.0	160,000.0	42.9
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.0	1,503,000.0	297,000.0	83.5
2105	Нормативт зардал	42,000.0	42,000.0	-	100.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	42,000.0	42,000.0	-	100.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,000,500.0	3,544,700.0	455,800.0	88.6
210604	Урсгал засвар	4,000,500.0	3,544,700.0	455,800.0	88.6
2107	Томилолт, зочны зардал	8,941,000.0	8,030,000.0	911,000.0	89.8
210702	Дотоод албан томилолт	8,941,000.0	8,030,000.0	911,000.0	89.8
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	167,466,400.0	81,239,332.0	86,227,068.0	48.5
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	163,720,400.0	78,476,650.0	85,243,750.0	47.9
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	330,000.0	-	330,000.0	-
210803	Даатгалын үйлчилгээ	900,000.0	843,210.0	56,790.0	93.7
210804	Тээврийн хэрэгслийн татвар	556,000.0	53,000.0	503,000.0	9.5
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	260,000.0	200,000.0	60,000.0	76.9

210807	Газрын төлбөр	1,700,000.0	1,666,472.0	33,528.0	98.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	5,542,400.0	5,000,000.0	542,400.0	90.2
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,000,000.0	5,000,000.0	-	100.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	542,400.0	-	542,400.0	-
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	400,000.0	-	400,000.0	-
2132	Бусад урсгал шилжүүлэг	400,000.0	-	400,000.0	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	400,000.0	-	400,000.0	-
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,235,307,400.0	1,218,066,105.0	17,241,295.0	98.6
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,231,707,400.0	1,212,720,200.0	18,987,200.0	98.5
132001	Орон нутгийн төсвөөс	1,231,707,400.0	1,212,720,200.0	18,987,200.0	98.5
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	3,600,000.0	5,345,905.0	(1,745,905.0)	148.5
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,600,000.0	5,345,905.0	(1,745,905.0)	148.5

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	-	62,066,320.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	-	62,066,320.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	-	62,066,320.00
2104	Хангамж, бараа материалын зардал	-	44,369,760.00
210402	Тээвэр, шатахуун	-	3,745,970.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	-	728,740.00
210404	Ном, хэвлэл	-	53,500.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	-	39,841,550.00
2105	Нормативт зардал	-	502,560.00
210502	Хоол, хүнс	-	502,560.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	-	1,553,000.00
210602	Тавилга	-	580,000.00
210604	Урсгал засвар	-	973,000.00
2107	Томилолт, зочны зардал	-	3,530,000.00
210702	Дотоод албан томилолт	-	3,530,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	-	12,111,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	-	12,111,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	-	119,702,126.70
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	119,702,126.70

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 188.5 сая төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 175.5 сая төгрөгийн 3 алдааг залруулсан. Үүнд:

1. Санхүүгийн үр дүнгийн тайланд гэрэл цахилгааны зардлыг 1.0 сая төгрөгөөр дутуу, түлш халаалтын зардлыг 6.7 сая төгрөгөөр дутуу, цэвэр бохир усны зардлыг 5.7 сая төгрөгөөр илүү, цалингийн зардлыг 4.1 сая төгрөгөөр илүү, үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг 0.5 сая төгрөгөөр дутуу тус тус зөрүүтэй тайлагнасанг залруулав.

2. Акталсан үндсэн хөрөнгийн дүнг 4.3 сая төгрөгөөр, бараа материалын дүнг 34.5 сая төгрөгөөр тус тус зөрүүтэй тусгасанг залруулав.

3. Санхүү байдлын тайланд: Үндсэн хөрөнгийн дүнг 2.7 сая төгрөгөөр илүү, Санхүүгийн үр дүнгийн тайланд: Үндсэн хөрөнгийн гарзыг 1.4 сая төгрөгөөр дутуу, үнэ төлбөргүй гарсан бараа материалыг 1.4 сая төгрөгөөр илүү, цалин хөлс болон нэмэгдэл урамшлын дүнг 0.4 сая төгрөгөөр дутуу, гэрэл цахилгааны зардлыг 0.5 сая төгрөгөөр дутуу, бичиг хэргийн зардлыг 0.4 сая төгрөгөөр илүү, Мөнгөн гүйлгээний тайланд: дээд шатны ТЗ-аас хуваарилсан орлогыг 21.0 сая төгрөгөөр дутуу, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлогыг 21.0 сая төгрөгөөр илүү, төвлөрүүлэх шилжүүлгийг 57.6 сая төгрөгөөр дутуу, Төсвийн гүйцэтгэлийн тайланд: Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлыг 1.5 сая төгрөгөөр дутуу, үндсэн дансны тайланд гүйцэтгэлийг 1.3 сая төгрөгөөр илүү, батлагдсан төлөвлөгөөг 3.9 сая төгрөгөөр илүү, тээврийн хэрэгслийн оношилгооны зардлын батлагдсан төлөвлөгөөг 0.2 сая төгрөгөөр илүү, бараа үйлчилгээний бусад зардлын төлөвлөгөөг 5.0 сая төгрөгөөр илүү тусгаж тус тус алдаатай тайлагнасанг залруулав.

Аудитаар залруулагдаагүй 37.1 сая төгрөгийн 5 зөрчилд албан шаардлага хүргүүлэв.

Нийт илрүүлсэн алдаа, зөрчлөөс 37.1 сая төгрөгийн залруулагдаагүй алдаа болон зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс 21.4 сая төгрөгөөр давсан тул *Хязгаарлалттай дүгнэлт* өглөө.

3.1 Албан шаардлага

1. Цалингийн зардлыг нийгмийн даатгалын 1-р сарын тайланд 0.3 сая төгрөгөөр, 2-р сарын тайланд 0.01 сая төгрөгөөр дутуу, эхний хагас жилийн байдлаар НДШ-ийн дүнг 0.6 сая төгрөгөөр илүү тайлагнасан, өмнөх оны зөвлөмжийн хэрэгжилтийг хангаагүй байгаа нь Нийгмийн даатгалын тухай хууль 32.2.2-т *“орон тоо болон цалин хөлсний сан, түүнтэй адилтгах орлогын бүрэлдэхүүнийг үнэн зөв тодорхойлж, нийгмийн даатгалын шимтгэлийг энэ хуулиар тогтоосон хувь хэмжээгээр ногдуулж, сар бүр нийгмийн даатгалын санд төлөх”* гэж заасантай нийцэхгүй байна

2. Нормын хувцас, зөөлөн эдлэлийн зардлаас бичиг хэргийн материал 0.04 сая төгрөгөөр, урсгал засварын зардлаас 0.3 сая төгрөгөөр жааз худалдан авсан нь Төсвийн тухай хуулийн 16.5.5-т *“батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах”* гэж заасантай нийцэхгүй байна.

3. Иргэдийн дунд "Софт волейболын тэмцээн" зохион байгуулж 0.6 сая төгрөгийг зарцуулсан байгаа нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.8. *“байгууллагын төсвөөр биеийн тамир, спортын уралдаан тэмцээн зохион байгуулахыг хориглоно”* гэж заасантай нийцэхгүй байна.

4. Өглөгийн 11.2 сая төгрөгийг үлдэгдлийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.6 *“эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах”* гэж заасантай нийцэхгүй байна.

5. Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж зардлаас 2.2 сая төгрөгийн мэдээллийн самбар, 1.5 сая төгрөгийн хүүхдийн бэлэг, 0.5 сая төгрөгийн программын төлбөрийг, Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс зардлаас 19.6 сая төгрөгийн өвс, тэжээл, Урсгал засвар зардлаас 0.05 сая төгрөгийн принтерийн засвар, 0.2 сая төгрөгийн бичиг хэргийн материал, 0.2 сая төгрөгөөр лицензийн төлбөрийг гарган зардлыг нэмэлт санхүүжилтийн данснаас эдийн засгийн ангилал зөрүүтэй зарцуулсан нь Засгийн газрын 2023 оны 444 дүгээр тогтоолоор батлагдсан “Төрийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 2 дугаар зүйлийн 2.12.1. *“Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлд заасан нэмэлт төсвийг өөрийн нэмэлт төсвийн дансаар дамжуулан хөтөлбөр, зориулалт, эдийн засгийн ангиллын дагуу зарцуулна”* гэсэн заалттай нийцэхгүй байна.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. АЛДАА ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Санхүүгийн тайланг алдаатай илэрхийлсэн.	1	18,000.4	-	-	1	18,000.4	1	18,000.4	-	-	-	-
Үндсэн хөрөнгө, бараа материалын дүнг алдаатай илэрхийлсэн	1	38,758.2			1	38,758.2	1	38,758.2				
Санхүүгийн байдлын тайлан, үр дүнгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг алдаатай илэрхийлсэн	1	118,698.8			1	118,698.8	1	118,698.8				
Дүн	3	175,457.4			3	175,457.4	3	175,457.4	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн	
							Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
НДШ-ийн тайланг зөрүүтэй тайлагнасан, зөрчлийг давтан гаргасан	1	917.7	-	-	1	917.7	-	-	-	-
Зардлыг зориулалт бусаар зарцуулсан	1	334.6	-	-	1	334.6	-	-	-	-
Өглөгийг тооцоо нийлсэн актаар баталгаажуулаагүй	1	10,984.4	-	-	1	10,984.4	-	-	-	-
Нэмэлт санхүүжилтийн данснаас зардлыг эдийн засгийн ангиллын дагуу зарцуулаагүй.	1	24,161.5	-	-	1	24,161.5	-	-	-	-
Дүн	4	36,398.2	-	-	4	36,398.2	-	-	-	-

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Албан шаардлага		Үүнээс	
							Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны хэрэгжилт хангалтгүй.	-	-	-	-	-	-	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	1	610.0	-	-	1	610.0	-	-
Дүн	-	-	-	-	-	-	-	-
Нийт дүн	1	610.0	-	-	1	610.0	-	-